

МОСТ ФИНТЕК ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН 2025 ОНЫ ЭЭЛЖИТ ХУРЛЫН МАТЕРИАЛ

ХУРЛЫН МАТЕРИАЛЫН АГУУЛГА

1

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зарлан хуралдуулах тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол

1.1. Хурал зарлах тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол

1.2. Хувьцаа эзэмшигчдийн анхааралд

1.3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалт

1.4. Санал авах хуудасны загвар

1.5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой материалын жагсаалт

1.6. Хурал зарлах мэдэгдэл

2

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэг

3

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой танилцах материал

3.1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан

3.2. Ногдол ашиг хуваариалах эсэхийг шийдвэрлэсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол

3.3. Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшигчдийн танилцуулга

3.4. Компанийн дүрмийн өөрчлөлт

4

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарах шийдвэрийн төсөл

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ ЗАРЛАН ХУРАЛДУУЛАХ ТУХАЙ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

МОСТ ФИНТЕК ХК

Монгол Улс, Улаанбаатар хот
Сүхбаатар дүүрэг, 8-р хороо
Сэнтрал Тауэр 13-р давхар, 1313 тоот

Утас: 75052727
Мэйл хаяг: info@most.mn



**МОСТ ФИНТЕК ХК-ИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЭЭЛЖИТ
ХУРЛЫН ТОГТООЛ**

2025 оны 03 сарын 14-ны өдөр

Дугаар *11/25*

Улаанбаатар хот

**Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг
зарлан хуралдуулах тухай**

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4 дэх хэсэг, 60 дугаар зүйл, 64 дүгээр зүйлийн 64.1, 64.2, 64.4 дэх заалт, 65 дугаар зүйл, 71 дүгээр зүйлийн 71.1, 71.3 дахь хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.2, 76.1.3 дахь заалт, Санхүүгийн Зохицуулах Хорооны 2018 оны 12 сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”, “МОСТ ФИНТЕК” ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн 7 дүгээр зүйлийн 7.39.4 дэх заалтыг тус тус үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаас **ТОГТООХ нь:**

1. Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал (цаашид “Хурал” гэх)-ыг 2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 14 цагт цахим /meet.most.mn/-аар зарлан хуралдуулсугай.
2. Хуралд оролцох эрхтэй Хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2025 оны 04 дүгээр сарын 08-ны өдрөөр тогтоосугай.
3. Хурал зарлах тухай мэдэгдлийг 2025 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн дотор Санхүүгийн Зохицуулах Хороо болон Биржид, 2025 оны 03 дугаар сарын 24-ны өдрийн дотор Хувьцаа эзэмшигчид үйлчилж байгаа Үнэт цаасны компаниудад тус тус хүргүүлсүгэй.
4. Хурал хуралдуулах тухай зар мэдээг Биржийн цахим хуудас, өдөр тутмын хоёроос доошгүй сонин болон бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан 2025 оны 03 дугаар сарын 19-ны өдрийн дотор нийтэд мэдээлж, уг зарын давталтыг 2025 оны 04 дүгээр сарын 03-ны өдөр анх зарласан хэлбэрээр дахин нийтэд мэдээлсүгэй.
5. Хурлын даргаар Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга А.Сүхдоржийг томилсугай.
6. Хурал зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд
Ажлын хэсгийн дарга дарга: Н.Урнаа /Захиргаа, Санхүүгийн газрын Захирал/
Гишүүд: Э.Цэлмэг /ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга/
Э.Цэнд /Бизнесийн газрын захирал/
Ж.Цолмонбаатар /Үйл ажиллагааны газрын захирал/
Д.Баасансүрэн /Дата аналитст/

7. Хурлын тооллогын ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд:
Ажлын хэсгийн дарга: Т.Отгонбаяр /Дата анализын газрын захирал/
Гишүүд: Б.Баярцэцэг /Төслийн менежер/
Д.Гэрэлтуяа /Бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн менежер/
8. Хурлын саналын хуудас /урьдчилан/-ыг брокер, дилерийн компаниудаар дамжуулан болон Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сүхбаатарын талбай, Сэнтрал тауэр оффисын 13 давхар 1313 тоот хаягаар санал хүлээн авах эцсийн хугацааг 2025 оны 04 дүгээр сарын 24-ны өдрийн 17:00 цаг байхаар тогтоосугай.
9. Хувьцаа эзэмшигчдийг ажлын өдрүүдийн 10:00-17:00 цаг хүртэл компанийн байранд болон цахимаар хурлын материалтай танилцах нөхцөл боломжийг бүрдүүлж ажиллахыг Хурал зохион байгуулах ажлын хэсэгт даалгасугай.
10. Энэхүү тогтоолын хавсралтаа дараах материалыг баталсугай.
 - 10.1 Хурлаар танилцуулах болон хэлэлцэх асуудлын жагсаалт – Хавсралт №01
 - 10.2 Саналын хуудасны загвар – Хавсралт №02
 - 10.3 Хурлын нийтэд хүргэх зар – Хавсралт №03
 - 10.4 Танилцах материалын жагсаалт- Хавсралт №04
11. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зарлан хуралдуулахтай холбогдон гарах зардлыг санхүүжүүлэхийг компанийн Гүйцэтгэх захирал /С.Оргил/-д зөвшөөрсүгэй.
12. Хурлын материалыг бэлэн болмогц брокер, дилерийн компаниудад хэвлэмэл болон цахим хэлбэрээр хүргүүлэх, цахим хуудсаараа хувьцаа эзэмшигчдэд танилцуулах болон хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалт, гарах шийдвэрийн төсөл, танилцуулга, саналын хуудас зэрэг бусад холбоотой баримт бичгийг хуулийн хугацаанд холбогдох байгууллагуудад хүргүүлэн ажиллахыг ажлын хэсэгт даалгасугай.
13. Хувьцаа эзэмшигчдийн хурлын санал хураалтыг цахим хэлбэрээр явуулах, үүнд санал хураалтад оролцогчийг системд бүртгэх, түүний саналыг авах, авсан саналын дүнг өөрчлөх боломжгүйгээр гүйцэтгэх, хуралд оролцогч бүрийн өгсөн саналыг хэвлэж, үнэн зөв болохыг баталгаажуулж, компанид хүлээлгэж өгөх үүрэг хүлээх зохих туршлага бүхий мэдээллийн технологийн компанитай ажил гүйцэтгэх гэрээ байгуулж ажиллахыг Гүйцэтгэх захирал /С.Оргил/-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

А.СҮХДОРЖ

УЛААНБААТАР ХОТ
УТЦ/742 5220351 9024050764

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРЛД

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 он 03 дугаар сарын
14 -ны өдрийн 11/25 тоот тогтоолын Хавсралт №03



“МОСТ ФИНТЕК” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ЗАР

Хурал болох газар: Цахимаар: www.meet.most.mn
Хурал болох өдөр, цаг: 2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 14:00 цагт
Компанийн оноосон нэр: “МОСТ ФИНТЕК” ХК

Хурлаар хэлэлцэх асуудал:

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлыг танилцуулна. Үүнд:

1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайлан;
2. Ногдол ашиг хуваарилах эсэх талаар шийдвэрлэсэн ТУЗ-ийн шийдвэр;

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлыг хэлэлцэж, шийдвэрлүүлнэ. Үүнд:

1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах;
2. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны төсөв батлах;
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнийг үүрэгт ажлаас чөлөөлж, шинээр сонгох тухай
4. Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг үүрэгт ажлаас нь чөлөөлж, шинээр сонгох тухай
5. Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;

Бүртгэлийн өдөр: 2025 оны 04 дүгээр сарын 08-ны өдөр

Хувьцаа эзэмшигчдийн танилцах баримт бичгийн жагсаалт:

1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарах шийдвэрийн төсөл;
2. Компанийн 2024 оны аудитлагдсан санхүүгийн тайлан;
3. Санхүүгийн жилийн тайлангийн талаарх аудитын байгууллагын дүгнэлт;
4. Компанийн дүрэм
5. Саналын хуудас;
6. Компанийн тухай хуулийн 65.6-д заасан шаардлагатай бусад бичиг баримт.

Хувьцаа эзэмшигчид өөрийн харилцагч үнэт цаасны компани, хурал зохион байгуулах комисстой холбогдож, эсхүл компанийн цахим хуудсаар дамжуулан хурлаар хэлэлцэх асуудал болон гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичигтэй танилцаж болно.

Хурал зохион байгуулах комиссын гишүүдтэй ажлын өдрүүдэд 09-17 цагийн хооронд дор дурдсан хаяг, утсаар холбогдох боломжтой.

Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сүхбаатарын талбай, Сэнтрал тауэр оффисын 13 давхар 1313 тоот

Харилцах утас: 7505-2727

Цахим шуудан: info@most.mn

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛЫН ЖАГСААЛТ

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 он 03 дугаар сарын
14 -ны өдрийн 11/25 тоот тогтоолын Хавсралт №01

“МОСТ ФИНТЕК” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛААР ТАНИЛЦУУЛАХ БОЛОН ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛЫН ЖАГСААЛТ

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлыг танилцуулна. Үүнд:

1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайланг танилцуулах;
2. Ногдол ашиг хуваарилах эсэх талаар шийдвэрлэсэн ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах;


Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлыг хэлэлцэж, шийдвэрлүүлнэ. Үүнд:

1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах;
2. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны төсөв батлах;
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнийг үүрэгт ажлаас чөлөөлж, шинээр сонгох тухай
4. Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг үүрэгт ажлаас нь чөлөөлж, шинээр сонгох тухай
5. Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;

-----oOo-----

САНАЛ АВАХ ХУУДАС №01

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 он 03 дугаар сарын 14 -ны өдрийн 11/25 тоот тогтоолын Хавсралт №02



“МОСТ ФИНТЕК” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН САНАЛ АВАХ ХУУДАС № 01

Хувьцаа эзэмшигчийн овог нэр: _____
 Регистрийн дугаар: _____
 Эзэмшиж буй хувьцааны төрөл: _____ Энгийн _____
 Эзэмшиж буй хувьцааны тоо: _____
 Бүртгэсэн брокер, дилерийн компани: _____
 Бүртгэсэн брокерийн овог нэр: _____

Энэхүү саналын хуудсаар 2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 14 цагт meet.most.mn хаягаар цахимаар хуралдах Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд санал өгнө.

№	Хурлаас гарах шийдвэрийн томъёолол	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
1.	Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаархи ТУЗ-ийн дүгнэлтийг батлах;			
2.	ТУЗ-ийн 2025 оны төсөв батлах;			
3.	Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах;			

Санал авах хуудас ашиглах заавар:

- Хувьцаа эзэмшигч нь саналын хуудас бөглөхдөө санал өгөх хэсэгт (✓) тэмдгийг бичнэ үү.
- Хувьцаа эзэмшигч нь өөрийн биеэр хуралд оролцож чадахгүй тохиолдолд өөрийн үйлчлүүлдэг үнэт цаасны компани дээр 2025 оны 04 сарын 24-ны өдрийн 17 цагаас өмнө очиж хурлын материалтай танилцаж санал өгнө.
- Хэрэв өөр этгээдээр төлөөлүүлэх бол төлөөлөх хүндээ итгэмжлэлийг хуульд заасан журмаар олгож, нотариатаар баталгаажуулсан байх ба уг итгэмжлэл нь зөвхөн энэ хурлын хувьд хүчинтэй байна.
- Хувьцаа эзэмшигч нь хувь хүн бол саналын хуудас дээр гарын үсэг зурж баталгаажуулах бөгөөд хэрэв хуулийн этгээд бол эрх бүхий этгээд гарын үсэг зурж, хуулийн этгээдийн тэмдгийг дарж баталгаажуулна.
- Засварласан болон балласан, залруулгатай санал авах хуудсыг хүчингүйд тооцно.
- Санал авах хуудас хүчингүйд тооцсон тухай шалтгааныг энд дурдана уу.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН БӨГЛӨХ ХЭСЭГ:

ХУВЬ ХҮН БОЛ:

Хувьцаа эзэмшигч иргэний овог, нэр:

.....

Гарын үсэг:.....

Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн овог, нэр:

.....

Регистрийн дугаар:

.....

Гарын үсэг:.....

ХУУЛИЙН ЭТГЭЭД БОЛ:

Хувьцаа эзэмшигч хуулийн этгээдийн нэр:

.....

Регистрийн дугаар:.....

Гарын үсэг:.....

Хувьцаа эзэмшигч хуулийн этгээдийг төлөөлж хуралд оролцсон итгэмжлэгдсэн төлөөлөгчийн нэр:

.....

Албан тушаал:.....

Гарын үсэг:.....

САНАЛ АВАХ ХУУДАС №02

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 он 03 дугаар сарын 14-ны өдрийн 11/25 тоот тогтоолын Хавсралт №02-үргэлжлэл

“МОСТ ФИНТЕК” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН САНАЛ АВАХ ХУУДАС № 02



Хувьцаа эзэмшигчийн овог нэр: _____
 Регистрийн дугаар: _____
 Эзэмшиж буй хувьцааны төрөл: _____ Энгийн _____
 Эзэмшиж буй хувьцааны тоо: _____
 Бүртгэсэн брокер, дилерийн компани: _____
 Бүртгэсэн брокерийн овог нэр: _____

Энэхүү саналын хуудсаар 2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 14 цагт meet.most.mn хаягаар цахимаар хуралдах Хувьцаа эзэмшигчийн ээлжит хуралд санал өгнө.

№	ТУЗ-ийн нэр дэвшигчдийн нэрс	Нэр дэвшигчид өгөх саналын тоо
Ердийн гишүүн		
1.		
2.		
Хараат бус гишүүн		
1.		
2.		

(Санамж: ТУЗ-ийн гишүүдийг сонгох санал хураалтыг кумулятив аргаар хураана. Тус арга нь санал өгөх эрхийн нийт тоо таны эзэмшиж байгаа саналын эрхтэй энгийн хувьцааны тоог сонгогдох гишүүний тоогоор үржүүлсэнтэй тэнцүү байна. Жишээ нь: та 100 ширхэг энгийн хувьцааг эзэмшдэг гэвэл тус компанийн ТУЗ нь 9 гишүүнтэй байхад үүнээс 3 гишүүн нь хараат бус гишүүн байхаар тогтоосон тохиолдолд Хувьцаа эзэмшигч эзэмшиж буй 100 ширхэг энгийн хувьцаа нь кумулятив аргаар санал өгөхөд нийт 900 саналын эрхтэй (100*9гишүүн=900) болох бөгөөд үүнээс 600 саналын эрхээрээ ТУЗ-ийн ердийн гишүүнээр сонгогдох 6 хүртэл нэр дэвшигчид, 300 саналын эрхээрээ ТУЗ-ийн хараат бус гишүүнээр сонгогдох 3 хүртэл нэр дэвшигчид тус тус санал өгөх эрхтэй болно гэдгийг анхаарна уу.)

Санал авах хуудас ашиглах заавар:

- Хувьцаа эзэмшигч нь саналын хуудас бөглөхдөө санал өгөх хэсэгт (✓) тэмдгийг бичнэ үү.
- Хувьцаа эзэмшигч нь өөрийн биеэр хуралд оролцож чадахгүй тохиолдолд өөрийн үйлчлүүлдэг үнэт цаасны компани дээр очиж хурлын материалтай танилцаж санал тэмдэглэн 2025 оны 04 дүгээр сарын 24-ны өдрийн 17 цагаас өмнө хүргүүлнэ.
- Хэрэв өөр этгээдээр төлөөлүүлэх бол төлөөлөх хүндээ итгэмжлэлийг хуульд заасан журмаар олгож, нотариатаар баталгаажуулсан байх ба уг итгэмжлэл нь зөвхөн энэ хурлын хувьд хүчинтэй байна.
- Хувьцаа эзэмшигч нь хувь хүн бол саналын хуудас дээр гарын үсэг зурж баталгаажуулах бөгөөд хэрэв хуулийн этгээд бол эрх бүхий этгээд гарын үсэг зурж, хуулийн этгээдийн тэмдгийг дарж баталгаажуулна.
- Засварласан болон балласан, залруулгатай санал авах хуудсыг хүчингүйд тооцно.
- Санал авах хуудас хүчингүйд тооцсон тухай шалтгааныг энд дурдана уу.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН БӨГЛӨХ ХЭСЭГ:

ХУВЬ ХҮН БОЛ:

Хувьцаа эзэмшигч иргэний овог, нэр:

.....

Гарын үсэг:.....

Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн овог, нэр:

.....

Регистрийн дугаар:

.....

Гарын үсэг:.....

ХУУЛИЙН ЭТГЭЭД БОЛ:

Хувьцаа эзэмшигч хуулийн этгээдийн нэр:

.....

Регистрийн дугаар:.....

Гарын үсэг:.....

Хувьцаа эзэмшигч хуулийн этгээдийг төлөөлж хуралд оролцсон

итгэмжлэгдсэн төлөөлөгчийн нэр:


.....

Албан тушаал:.....

Гарын үсэг:.....

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛТАЙ ХОЛБООТОЙ МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 он 03 дугаар сарын
14 -ны өдрийн 11/25 тоот тогтоолын Хавсралт №04



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛД БЭЛТГЭХ ЯВЦАД ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ТАНИЛЦАЖ БОЛОХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ


1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарах шийдвэрийн төсөл;
2. Компанийн 2024 оны аудитлагдсан санхүүгийн тайлан;
3. Санхүүгийн жилийн тайлангийн талаарх аудитын байгууллагын дүгнэлт;
4. Компанийн дүрэм;
5. Саналын хуудас;
6. Компанийн тухай хуулийн 65.6-д заасан шаардлагатай бусад бичиг баримт.

ХУРАЛ ЗАРЛАХ МЭДЭГДЭЛ

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН МЭДЭГДЭЛ

Компанийн нэр:	“МОСТ ФИНТЕК” ХК
Хаяг:	Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Их сургуулийн гудамж, Сэнтрал тауэр, 13 давхар, 1313 тоот
Хурал хуралдах өдөр, цаг:	2025 оны 04 дүгээр сарын 25-ны 14:00 цагт
Хурал хуралдах газар /хаяг, байршил/:	Цахимаар www.meet.most.mn
Хурлын төрөл	Ээлжит
Хурал зарлагч:	Төлөөлөн Удирдах Зөвлөл
Хурал хуралдах шийдвэр гаргасан огноо:	2025 оны 03 дугаар сарын 14-ний өдөр
Олон нийтэд зарлах огноо:	2025 оны 03 дугаар сарын 19-ны дотор 2025 оны 04 дүгээр сарын 03-ны дотор
Бүртгэлийн өдөр:	2025 оны 04 дүгээр сарын 08-ны өдөр
Гэрээний дагуу хурлын баримт бичгийг брокер, дилерийн компанид хүргүүлэх огноо:	2025 оны 03 дугаар сарын 24-ний дотор
Хүргүүлсэн огноо:	2025 оны 03 дугаар сарын 17-ны өдөр
Хурлын даргын нэр:	Авир овогтой Сүхдорж
Тооллогын комиссын дарга, гишүүдийн нэр:	Ажлын хэсгийн дарга: Т.Отгонбаяр Гишүүд: Б.Баярцэцэг Д.Гэрэлтуяа
Баримт бичгийн жагсаалт /хавсралтаар/:	1. Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол 2. Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар 3. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал 4. Хувьцаа эзэмшигчдийн хурлын саналын хуудасны загвар 5. Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарах шийдвэрийн төсөл
Баримт бичгийн хуудас хуудас

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИССЫН ДАРГА


..... /Н.УРНАА/

2025 оны 03 дугаар сарын 17-ны өдөр

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДЭГ

Хурал 2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 14:00 цагт эхэлнэ.

Хугацаа	Хөтөлбөр	Хариуцагч
14:00-14:15	Тооллогын комисс хурлын ирц бүртгэх, ирцийг мэдээллэх	Тооллогын комисс
14:15-14:20	Хурлын дарга хурлыг нээж, хурлаар хэлэлцүүлэх асуудлууд болон хурлын дэгийг танилцуулах	Хурлын дарга А.Сүхдорж
14:20-15:20	Хэлэлцэх асуудлыг жагсаалтын дагуу танилцуулах: 1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайланг танилцуулах; 2. Ногдол ашиг хуваарилах эсэх талаар шийдвэрлэсэн ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах; 3. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны төсөв батлах; 4. Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнийг үүрэгт ажлаас чөлөөлж, шинээр сонгох тухай 5. Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг үүрэгт ажлаас нь чөлөөлж, шинээр сонгох тухай 6. Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;	Гүйцэтгэх захирал С.Оргил
15:20-15:50	Хэлэлцэж буй асуудалтай холбоотой асуулт, хариулт	Гүйцэтгэх захирал С.Оргил
15:50-16:10	Санал хураалт, санал тоолох	Тооллогын комисс
16:10-16:20	Тооллогын комисс санал хураалтын дүнг хэлэлцсэн асуудал бүрээр танилцуулах	Тооллогын комисс
16:20-16:30	Хурлаас гарах тогтоолын төслийг танилцуулж, хурлыг хаах	Хурлын дарга А.Сүхдорж

Хурал үргэлжлэх хугацаа: 2 цаг 30 минут

Жич: Хурал хөтлөх явцад шаардлагатай тохиололд хурлын хугацаанд өөрчлөлт орж болно.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ

1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайланд гаргасан Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах;
2. Ногдол ашиг хуваарилах эсэх талаар шийдвэрлэсэн ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах;
3. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны төсөв батлах;
4. Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнийг үүрэгт ажлаас чөлөөлж, шинээр сонгох тухай;
5. Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг үүрэгт ажлаас нь чөлөөлж, шинээр сонгох тухай;
6. Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;

КОМПАНИЙН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТАНИЛЦУУЛГА

2024 оны үйл ажиллагааны тайлан

	2023 Q2		2023 Q3		2023 Q4		2024 Q1		2024 Q2		2024 Q3		2024 Q4	
	Тоо /мян/	Дүн	Тоо /мян/	Дүн	Тоо /мян/	Дүн	Тоо /мян/	Дүн	Тоо /мян/	Дүн	Тоо /мян/	Дүн	Тоо /мян/	Дүн
Монголбанк	264,934	100,170	267,714	104,136	288,358	112,457	269,410	104,698	329,128	135,979	332,153	141,894		
МОСТ	6,030	2,346	6,166	2,427	7,743	2,194	6,184	2,910	7,730	3,047	7,935	2,754	8,589	2,949
Эзлэх хувь	2.3%	2.3%	2.3%	2.3%	2.7%	2.0%	2.3%	2.8%	2.3%	2.2%	2.4%	1.9%		

Банк
6



ББСБ
45 +10



Мерчант
40'779 +359



Биллер
873 +193



Хэтэвч
33 +9



Хэрэглэгч
1,85сая +8%




Гүйлгээ
31сая +19%




2024 өсөлт


Хэрэглэгчийн тоо



Гүйлгээний тоо



Зээл олголт



Банк хамтын ажиллагаа

АРИГ БАНК

- ПОС орлого барьцаалсан зээл
- Мост Мони-д OTP данс нэмэх боломж

TransBank

- Мост Мони-д OTP данс нэмэх боломж

KHAN BANK

- DIGI Pay апп дээр Тээврийн хэрэгсэл цэс




ГОПОМТ БАНК

Сайн сайхны санхүүжилэл


ТӨРИЙН БАНК

Төлөвлөгөө гүйцэтгэл

Хэрэглэгчийн тоо



Гүйлгээний тоо



Банк бус санхүүгийн байгууллага

Онлайн зээл

- ✓ ПОС орлого барьцаалсан зээл



МОНГОЛЫН БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ХОЛБОО

- ✓ Хамтын ажиллагааны санамж бичиг байгуулав



MostMoney


- ✓ 7 Банк Бус Санхүүгийн Байгууллага

WHITELABEL




Төлөвлөгөө гүйцэтгэл

Хэрэглэгчийн тоо



Гүйлгээний тоо



Зээл+кредит Скоп



Төлөвлөгөө гүйцэтгэл


Биллер

- Нийт 717 Биллер МОСТ-д бүртгэлтэй байна
- 2024 онд Шинээр 183



МОСТ-той гэрээтэй биллер

Гүйлгээний тоо



Мерчант

Мерчант төв

- Аравт
- Зочил
- Ultimate Solution
- Масы
- NSP
- CoreMind


Мерчант

- Артисан /Tous Les Jours/
- Mom's Touch
- UbEats
- +10
- Ард мерчант 120+

Онцлох

- ККТТ үнийн дүн дамжуулдаг болов
- Pick n Pay-г Смарт Ложикийн ECR-тай холбов
- 794 мерчант дээр шимтгэл тохируулав

Гүйлгээний тоо



Системийн найдвартай ажиллагааны үзүүлэлт:

2024 онд системийн хэвийн үйл ажиллагааг 99,98% хангаж ажилласан байна.

Системийн үзүүлэлт	Тасалдал (мин)		Нийт ажилласан (мин)	Үзүүлэлт (%)
	Төлөвлөгөөт	Төлөвлөгөөт бус		
Q1	20	29	129600	99.97%
Q2	25	51	131040	99.96%
Q3	20	0	132480	100%
Q4	25	22	131040	99.98%



МОСТ Групп




Санхүүгийн гүйцэтгэл: гол үзүүлэлт /сая төгрөгөөр/


Нийт хөрөнгө ба өөрийн хөрөнгө



Нийт орлого



Цэвэр ашиг



САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Мянган төгрөгөөр	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31	Өөрчлөлт төгрөгөөр	Өөрчлөлт хувиар
Хөрөнгө				
Эргэлтийн хөрөнгө				
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	827,868,193	774,338,031	(53,530,162)	-6.5%
Дансны авлага болон бусад авлага	7,179,063,428	3,901,219,552	(3,277,843,876)	-45.7%
Бараа материал	536,743	878,458	341,715	63.7%
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	1,448,151,991	430,885,755	(1,017,266,236)	-70.2%
Бусад эргэлтийн хөрөнгө	1,000,000,000	1,900,000,000	900,000,000	90.0%
	10,455,620,354	7,007,321,795	(3,448,298,560)	-33.0%
Эргэлтийн бус хөрөнгө				
Үндсэн хөрөнгө	759,885,234	755,258,212	(4,627,021)	-0.6%
Биет бус хөрөнгө	4,940,165,457	4,934,918,147	(5,247,310)	-0.1%
Урт хугацаат хөрөнгө оруулалт	523,451,788	1,828,094,852	1,304,643,064	3.5x
Бусад эргэлтийн бус хөрөнгө	-	2,745,139,043	2,745,139,043	100.0%
	6,223,502,479	10,263,410,254	4,039,907,776	64.9%
Нийт хөрөнгө	16,679,122,833	17,270,732,049	591,609,216	3.5%
Өр төлбөр ба эздийн өмч				
Богино хугацаат өр төлбөр				
Дансны болон бусад өглөг	668,317,457	454,106,543	(214,210,914)	-32.1%
Татвар, НДШ-ийн өглөг	102,095,365	85,680,129	(16,415,236)	-16.1%
Хойшлогдсон татварын өр		17,157,119	17,157,119	100.0%
	770,412,822	556,943,792	(213,469,031)	-27.7%
Өр төлбөрийн нийт дүн	770,412,822	556,943,792	(213,469,031)	-27.7%
Эздийн өмч				
Хувь нийлүүлсэн хөрөнгө	4,859,697,000	4,859,697,000	-	0.0%
Халаасны хувьцаа		(272,160,007)		100.0%
Нэмж төлөгдсөн капитал	6,795,689,845	6,795,689,845	-	0.0%
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	3,307,858,509	3,299,884,178	(7,974,331)	-0.2%
Эздийн өмчийн бусад хэсэг		154,414,071		100.0%
Хуримтлагдсан ашиг алдагдал	945,464,657	1,876,263,171	930,798,514	98.4%
Эздийн өмчийн дүн	15,908,710,011	16,713,788,257	805,078,247	5.1%
Нийт өр төлбөр ба эздийн өмч	16,679,122,833	17,270,732,049	591,609,216	3.5%
	0	0		

ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

Мянган төгрөгөөр	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31	Өөрчлөлт төгрөгөөр	Өөрчлөлт хувиар
Борлуулалтын орлого (цэвэр)	1,700,612,828	2,386,651,006	686,038,178	40.3%
Борлуулсан барааны өртөг	91,130,782	85,755,786	(5,374,996)	-5.9%
Нийт ашиг (алдагдал)	1,609,482,046	2,300,895,220	691,413,174	43.0%
Хүүний орлого	234,285,847	696,117,235	461,831,387	3x
Бусад орлого	-	-	-	-
Борлуулалт, маркетингийн зардал	469,611,334	562,061,592	92,450,258	19.7%
Ерөнхий ба удирдлагын зардал, бусад зардал	1,181,083,851	1,416,914,689	235,830,838	20.0%
Бусад олз (гарз)	177,685	1,920,114	1,742,429	10.8x
Татварын өмнөх ашиг (алдагдал)	193,250,394	1,019,956,288	826,705,894	5.3x
Орлогын татварын зардал	23,428,585	97,132,105	73,703,521	4.1x
Татварын дараах ашиг (алдагдал)	169,821,809	922,824,183	753,002,374	5.4x
Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал	169,821,809	922,824,183	753,002,374	5.4x
Бусад дэлгэрэнгүй орлого	1,499,040,000	-	(1,499,040,000)	-100.0%
Орлогын нийт дүн	1,668,861,809	922,824,183	(746,037,626)	-44.7%

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Мянган төгрөгөөр	Өмч	Халаасны хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2022 оны 12-р сарын 31	3,547,578,800	-	3,026,502,644	3,308,788,509	-	(724,327,152)	9,158,542,801
Залруулсан үлдэгдэл	3,547,578,800	-	3,026,502,644	3,308,788,509	-	(724,327,152)	9,158,542,801
Тайлант үеийн ашиг (алдагдал)	-	-	-	-	-	1,668,861,809	1,668,861,809
2023 оны 12-р сарын 31	4,859,697,000	-	6,795,689,845	3,307,858,509	-	945,464,657	15,908,710,011
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн	-	-	-	-	-	-	-
Залруулсан үлдэгдэл	4,859,697,000	-	6,795,689,845	3,307,858,509	-	945,464,657	15,908,710,011
Тайлант үеийн ашиг (алдагдал)						922,824,183	922,824,183
Бусад дэлгэрэнгүй орлого							-
Өмчид гарсан өөрчлөлт		(272,160,007)		(7,974,331)	154,414,071	7,974,331	(117,745,936)
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн							-
2024 оны 12-р сарын 31	4,859,697,000	(272,160,007)	6,795,689,845	3,299,884,178	154,414,071	1,876,263,171	16,713,788,257

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Мянган төгрөгөөр	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(171,556,844)	119,855,115
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн	(4,772,661,569)	98,775,094
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	5,715,586,379	(272,160,007)
Валютын ханшны зөрүү	1,042	(364)
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	771,369,008	(53,530,162)
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	56,499,185	827,868,193
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	827,868,193	774,338,031

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

МОСТ Финтек ХК-ийн хувьцаа эзэмшигчид

Дүгнэлт

Бид МОСТ Финтек ХК (цаашид “компани” гэх)-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр тасалбар болгосон орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон бусад тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бид, компанийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, уг өдрөөр тасалбар болгосон орлогын дэлгэрэнгүй тайлан, мөнгөн гүйлгээг бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (цаашид “СТОУС” гэх)-ын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн байна гэж дүгнэж байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт (цаашид “АОУС” гэх)-ын дагуу гүйцэтгэсэн болно. Уг стандартын дагуу бидний хүлээх үүргийг энэхүү тайлангийн Санхүүгийн Тайлангийн Аудиттай холбоотой Аудиторын Үүрэг хэсэгт тусгасан. Бид Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Стандартын Зөвлөлөөс баталсан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм (цаашид “МНБЁЗ-н дүрэм” гэх)-ийн дагуу компаниас хараат бус ба МНБЁЗ-н дүрмийн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь аудитын дүгнэлт гаргах хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэж итгэж байна.

Санхүүгийн тайлантай холбоотой Удирдлага болон Засаглах Эрх Бүхий Этгээдийн Үүрэг

Удирдлага нь санхүүгийн тайлангаа СТОУС-ын дагуу бэлтгэн, шударгаар илэрхийлэх, эдгээр санхүүгийн тайланг алдаа эсвэл санаатай зальт үйлдлээс үүсэлтэй материаллаг хэмжээний алдаагүйгээр бэлтгэж, шударгаар илэрхийлэхийн тулд удирдлагаас шаардлагатай гэж тогтоосон дотоод хяналтыг хэрэгжүүлэх үүрэгтэй.

Санхүүгийн тайланг бэлтгэхдээ компанийн татан буулгах, үйл ажиллагааг нь зогсоох, эсвэл үүнээс өөр боломжит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд Удирдлага компанийн үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах чадамжийг үнэлэх, тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг ашиглан санхүүгийн тайлангаа бэлтгэх үүрэгтэй.

Засаглах эрх бүхий этгээд нь компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэгтэй.

Санхүүгийн Тайлангийн Аудиттай холбоотой Аудиторын Үүрэг

Санхүүгийн тайлан нь бүхэлдээ алдаа эсвэл санаатай зальт үйлдлийн улмаас материаллаг хэмжээний алдаагүй илэрхийлэгдсэн эсэх талаар үндэслэлтэй нотолгоо олж авах болон бидний дүгнэлтийг агуулсан аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Үл үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудит нь байнга

▲ “Хүлээгтхүннү аудит” ХХК
Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
5-р хороо, Самбуугийн гудамж, Эм Эн тауэр, 808 тоот.
Утас/Факс: +(976)-7014 0505



материаллаг хэмжээний алдааг илрүүлдэг гэсэн баталгаа болохгүй. Алдаатай илэрхийлэл нь алдаа эсвэл санаатай зальт үйлдлээс үүсч болох ба дангаараа эсвэл нийтдээ эдгээр санхүүгийн тайланд үндэслэн шийдвэр гаргах санхүүгийн тайлангийн хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллаг гэж үздэг.

АОУС-ын дагуу хийсэн аудитын нэг хэсэг байдлаар бид мэргэжлийн шийдэл гарган, аудитын туршид мэргэжлийн үл итгэх үзлийг баримтлан ажилладаг. Үүнээс гадна:

- Заль мэх эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлан материаллаг алдаатай илэрхийлэгдэх эрсдлийг тодорхойлж, түүнийг үнэлэн уг эрсдэлд тохирох аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж, өөрсдийн санал дүгнэлтийн үндэслэл болохуйц хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоог олж авдаг. Заль мэхнээс үүссэн материаллаг алдааг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүссэн материаллаг алдааг илрүүлэхгүй байх эрсдэлээс харьцангуй их байдаг. Учир нь заль мэхэнд хуйвалдаан, баримт бичгийг хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу тайлагнах, дотоод хяналтыг үл ойшоох явдлууд орсон байж болно.
- Компанийн дотоод хяналтын үр ашигт байдлын талаар санал дүгнэлт гаргах зорилгоор биш харин тухайн нөхцөл байдалд тохирох аудитын горимыг боловсруулах зорилгоор аудитад хамаарах дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.
- Удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн бодлогын тохиромжтой байдал, хийсэн нягтлан бодох бүртгэлийн тооцоолол болон холбогдох тодруулгын үл үндэслэлтэй байдлыг үнэлдэг.
- Мөн олж авсан аудитын нотолгоон дээр үндэслэн компанийн тасралтгүйгээр үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх чадамжид мэдэгдхүйц эргэлзээ төрүүлэхүйц үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал байгаа эсэхийг тодорхойлж, нягтлан бодох бүртгэлийн өөдрөг төсөөллийн суурийг удирдлага зохистойгоор хэрэглэсэн эсэхийг дүгнэдэг. Хэрэв бид материаллаг хэмжээний тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл аудиторын тайландаа түүнтэй холбоотой санхүүгийн тайлангийн тодруулгад анхаарал хандуулах эсвэл хийсэн тодруулга нь хангалтгүй байна гэж үзвэл аудитын санал дүгнэлтээ өөрчилдөг. Бидний дүгнэлт нь аудиторын тайлан гаргах өдөр хүртэлх олж авсан аудитын нотолгоонд суурилдаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал эсвэл нөхцөлүүд нь компанийг өөдрөг төсөөллөө үргэлжлүүлэхээ зогсооход хүргэх нөлөө үзүүлж болно.
- Тодруулгыг багтаагаад санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, бүтэц, агуулга ба санхүүгийн тайлангууд нь үнэн зөв толилуулгын шаардлагыг хангахуйц хэмжээнд гол гол ажил гүйлгээ ба үйл явдлыг илэрхийлсэн эсэхийг үнэлдэг.

Бид аудитын төлөвлөсөн цар хүрээ ба хугацаа, аудитынхаа явцад олж илрүүлсэн дотоод хяналт дахь томоохон зөрчил, дутагдлыг оруулаад нөлөө бүхий аудитын илрүүлэлтүүд, бусад асуудлуудаар засаглах эрх бүхий удирдлагатай харилцдаг.

Гарын үсэг зурсан:



И.Гүррагча
Гүйцэтгэх захирал
Хүлэгтхүннү Аудит ХХК

2025 оны 03 дугаар сарын 12-ны өдөр
Монгол Улс, Улаанбаатар хот

▲ "Хүлэгтхүннү аудит" ХХК
Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
5-р хороо, Самбуугийн гудамж, Эм Эн тауэр, 808 тоот.
Утас/Факс: +(976)-7014 0505

6

МОСТ ФИНТЕК ХК

Монгол Улс, Улаанбаатар хот
Сүхбаатар дүүрэг, 8-р хороо
Сэнтрал Тауэр 13-р давхар, 1313 тоот

Утас: 75052727
Мэйл хаяг: info@most.mn



МОСТ ФИНТЕК ХК-ИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЭЭЛЖИТ
ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 03 сарын 14-ны өдөр

Дугаар *05/25*

Улаанбаатар хот

*Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон
аудитлагдсан санхүүгийн тайлангийн
талаар дүгнэлт гаргах тухай*

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.11 дэхь заалт, “МОСТ ФИНТЕК” ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.39.6 дахь заалтыг тус тус үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаас **ТОГТООХ нь:**

1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны тайланг “Хангалттай” хэмээн дүгнэсүгэй.
2. Компанийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон, СТОУС-ын дагуу бэлтгэсэн санхүүгийн тайланд холбогдох хууль тогтоомжийн дагуу хөндлөнгийн аудит хийсэн “Хүлэгт хүннү аудит” ХХК-ийн гаргасан хараат бус аудиторын дүгнэлтийг хүлээн зөвшөөрсүгэй.
3. Энэхүү тогтоолын 2-т заасан тайланг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохих эрх бүхий байгууллагад хүргүүлж, шаардлагатай арга хэмжээг авч ажиллахыг компанийн Гүйцэтгэх захирал /С.Оргил/-д даалгасугай.
4. Компанийн үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайланг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулж, зохих шийдвэрийг гаргуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга /А.Сүхдорж/-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

А.СҮХДОРЖ



НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАХ ЭСЭХ ТАЛААР ГАРГАСАН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ШИЙДВЭР

МОСТ ФИНТЕК ХК

Монгол Улс, Улаанбаатар хот
Сүхбаатар дүүрэг, 8-р хороо
СЭНТРАЛ ТАУЭР 13-р ДАВХАР, 1313 ТООТ

Утас: 75052727
Мэйл хаяг: info@most.mn



МОСТ ФИНТЕК ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 02 сарын 18-ны өдөр

Дугаар: 02/25

Улаанбаатар хот

Ногдол ашиг хуваарилахгүй байх тухай

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 46.2, 46.5, 46.6 дахь хэсэг, “МОСТ ФИНТЕК” ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн 10 дугаар зүйлийн 10.1, 10.5 болон компанийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компани нь 2024 оны цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилахгүй байхаар тогтоосугай.
2. Энэхүү шийдвэрийг 2025 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулахыг Төлөөн Удирдах Зөвлөлийн даргад даалгасугай.
3. Энэхүү шийдвэрийг эрх бүхий байгууллага болон олон нийтэд мэдээлэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн даргад даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА
А.СҮХДОРЖ



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН 2025 ОНЫ ТӨСӨВ БАТЛАХ ТУХАЙ

МОСТ ФИНТЕК ХК

Монгол Улс, Улаанбаатар хот
Сүхбаатар дүүрэг, 8-р хороо
СЭНТРАЛ ТАУЭР 13-р ДАВХАР, 1313 ТООТ

Утас: 75052727
Мэйл хаяг: info@most.mn



МОСТ ФИНТЕК ХК-ИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны ¹²... сарын ²⁵...-ны өдөр

Дугаар ²⁵.../24

Улаанбаатар хот

Компанийн 2025 оны бизнес төлөвлөгөө, төсвийг батлах тухай

ТУЗ-ийн дэргэдэх Бизнесийн бодлогын хорооны 2024 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн дүгнэлт, ТУЗ-ийн хурлаас санал хураасан дүнг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн 2025 оны бизнес төлөвлөгөөг хавсралт ёсоор баталсугай.
2. Батлагдсан бизнес төлөвлөгөөг мөрдөж ажиллахыг гүйцэтгэх захиралд үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА  А.СҮХДОРЖ



УЛААНБААТАР ХОТ

МОСТ ФИНТЕК ХК-ИЙН
ТУЗ-ИЙН 2024 ОНЫ 03 САРЫН 15-НЫ
ӨДРИЙН ХУРЛЫН 08/24 ДУГААРТАЙ
ТОГТООЛЫН ХАВСРАЛТ.

1118267282 5220351

Мянган төгрөгөөр

№	Зардлын төрөл	1 гишүүний цалингийн зардал (хурлын ирцээр)	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал	Нийт зардал
1	Суурь цалин:						
	ТУЗ-н дарга	1,300,0	1,300,0	1,300,0	1,300,0	1,300,0	5,200,0
	ТУЗ-н гишүүн	900,0	7,200,0	7,200,0	7,200,0	7,200,0	28,800,0
2	Ээлжит бус хурлын нэмэгдэл	150,0	1,350,0	1,350,0	1,350,0	1,350,0	5,400,0
3	Хорооны нэмэгдэл						
	Хорооны дарга	150,0	450,0	450,0	450,0	450,0	1,800,0
	Хорооны гишүүн	100,0	600,0	600,0	600,0	600,0	2,400,0
4	НДШ-н зардал		1,308,0	1,308,0	1,308,0	1,308,0	5,232,0
5	Бусад з.байгуулалтын зардал		100,0	100,0	100,0	100,0	400,0
	Нийт төсөв		12,308,0	12,308,0	12,308,0	12,308,0	49,232,0

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧДИЙН ТАНИЛЦУУЛГА

/МОСТ Финтек ХК-ийн Төлөөлөн Удирдах
Зөвлөлийн хараат бус гишүүнд нэр дэвшигч/

Нэг. Ерөнхий мэдээлэл

Эцэг/эх/-ийн нэр: **Болдбаатар**

Өөрийн нэр: **Баатармөнх**

Иргэншил: **Монгол**

Төрсөн он сар: **1982.10**



Хоёр. Ерөнхий мэдээлэл

Сургуулийн нэр	Байршил	Элссэн-Төгссөн он	Эзэмшсэн мэргэжил
Баруун Мичиганы Их Сургууль	АНУ, Мичиган	2001-2005	Нисэхийн шинжлэх ухаан /Бакалавр/
Баруун Мичиганы Их Сургууль	АНУ, Мичиган	2007-2009	Санхүүд мэргэшсэн, Хөрөнгө оруулалтын сангийн удирдах сурагчаар сонгогдсон /Магистр/

Гурав. Ажлын туршлага

Байгууллагын нэр	Албан тушаал	Ажилласан хугацаа
Баруун Мичиганы Их Сургууль/АНУ/	Багш нисгэгч	2005-2010
Изинис Монгол ХХК	Нисгэгч/ Нислэгийн үйл ажиллагаа эрхэлсэн дэд захирал	2010-2014
Ванилла Эйр/ Япон	Нисгэгч	2014-2017
ЖэтСтар Ази/ Сингапур	Нисгэгч	2017-2021
Ньюком групп	Гүйцэтгэх захирал	2022 оноос хойш

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧДИЙН ТАНИЛЦУУЛГА

/МОСТ Финтек ХК-ийн Төлөөлөн Удирдах
Зөвлөлийн ердийн гишүүнд нэр дэвшигч/

Нэг. Ерөнхий мэдээлэл

Эцэг/эх/-ийн нэр: **Гүррагчаа**

Өөрийн нэр: **Сүхбаатар**

Иргэншил: **Монгол**

Төрсөн он сар: **1982.02**



Хоёр. Ерөнхий мэдээлэл

Сургуулийн нэр	Байршил	Элссэн-Төгссөн он	Эзэмшсэн мэргэжил
Монгол Улсын Их Сургууль	Монгол	2000-2004	Нягтлан бодогч
Газарчин дээд сургууль	Монгол	2019-2020	Бизнесийн менежмент

Гурав. Ажлын туршлага

Байгууллагын нэр	Албан тушаал	Ажилласан хугацаа
Хас банк	Эдийн засагч Салбарын захирал Зээлийн хяналтын ахлах мэргэжилтэн	2005-2016
Ард кредит ББСБ	Зээлийн менежер Гүйцэтгэх захирлын орлогч, Зээл, бизнес эрхэлсэн захирал	2017-2024
Ард кредит ББСБ	Гүйцэтгэх захирал	2024 оноос хойш

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧДИЙН ТАНИЛЦУУЛГА

/МОСТ Финтек ХК-ийн Төлөөлөн Удирдах
Зөвлөлийн ердийн гишүүнд нэр дэвшигч/

Нэг. Ерөнхий мэдээлэл

Эцэг/эх/-ийн нэр: **Балданжамц**

Өөрийн нэр: **Ганболд**

Иргэншил: **Монгол**

Төрсөн он сар: **1974.04**



Хоёр. Ерөнхий мэдээлэл


Сургуулийн нэр	Байршил	Элссэн-Төгссөн он	Эзэмшсэн мэргэжил
Шинжлэх ухаан технологийн их сургууль	Монгол	2000-2004	Компьютерийн техник хангамжийн инженер

Гурав. Ажлын туршлага

Байгууллагын нэр	Албан тушаал	Ажилласан хугацаа
БСБ Сервис ХХК	Сүлжээний инженер	1997 – 1998
	Мэдээлэл технологийн газрын дарга	1998 – 2000
ГрэйпСити Монгол ХХК	Ерөнхийлөгч	2000 – 2018
	Бүтээгдэхүүн хариуцсан захирал	2018 оноос хойш

КОМПАНИЙН ДҮРЭМД ОРУУЛАХ ӨӨРЧЛӨЛТ

МОСТ Финтек ХК нь дараах компаниудын хувьцааг эзэмшдэг. Үүнд:



Эдгээр компаниуд нь ХХК-ийн статустай бөгөөд тус компаниудад эзэмшиж буй хувьцаанд ногдох Хувьцаа эзэмшигчдийн эрхийг хэрэгжүүлэхдээ заавал Хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлүүлэхээр МОСТ-н дүрэмд тусгагдсан байгаа. Энэ нь ХК-ийн статустай МОСТ-н хувьд хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлах, хуралдуулах хуулийн хугацаат шаардлагуудаас үүдэн дээрх компаниудын үйл ажиллагаанд цаг хугацааны хувьд чирэгдэл үүсгэх, яаралтай шийдвэрлэх асуудлуудад хугацаа алдах, зардлыг нэмэгдүүлэх нөхцөлийг бий болгож байгаа тул мэргэшсэн гишүүдээс бүрдсэн Төлөөлөн удирдах зөвлөлдөө тус эрхийг хэрэгжүүлэх бүрэн эрхийг шилжүүлэх зорилготой юм. Иймд Компанийн Хувьцаа эзэмшигчдийн 2024 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн ХЭХ#02/24 тоот шийдвэрийн хавсралтаар “МОСТ Финтек” ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.39.1 - д : “ХЭХ-аас эрх олгосны үндсэн дээр Компанийн охин, хараат компаниудын ХЭХ-ын бүрэн эрхийг хэрэгжүүлэх” гэснийг **“Компанийн охин, хараат компаниудын ХЭХ-ын бүрэн эрхийг хэрэгжүүлэх”** гэж өөрчлөх саналыг хувьцаа эзэмшигчийн ээлжит хурлаар шийдвэрлүүлэхээр тогтлоо.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛААС ГАРАХ ШИЙДВЭРИЙН ТӨСӨЛ

ГАРАХ ШИЙДВЭРИЙН ТӨСӨЛ

**Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайланд
Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах тухай**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, “МОСТ ФИНТЕК” ХК-ийн дүрмийн холбогдох заалт, компанийн 2025 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын тоот тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. “МОСТ ФИНТЕК” ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайланд Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 05/25 тоот тогтоолоор өгсөн дүгнэлтийг хүлээн зөвшөөрч, баталсугай.

ХУРЛЫН ДАРГА

А.СҮХДОРЖ

ГАРАХ ШИЙДВЭРИЙН ТӨСӨЛ

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны төсөв батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13 дахь заалт, “МОСТ ФИНТЕК” ХК-ийн дүрмийн холбогдох заалт, компанийн 2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын тоот тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. “МОСТ ФИНТЕК” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны төсвийг Хавсралтаар баталсугай.
2. Энэхүү шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг Гүйцэтгэх захирал /С.Оргил/-д үүрэг болгосугай

ХУРЛЫН ДАРГА

А.СҮХДОРЖ

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт, 63 дугаар зүйлийн 63.6 дахь хэсэг, 77 дугаар зүйлийн 77.1 дэхь хэсэг, 2025 оны 04 сарын 25-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын ... дугаартай тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн ТҮЗ-ийн гишүүнийг сонгох асуудалд хувьцаа эзэмшигчдийн олонхын санал авсан дараах нэр дэвшигчийг ТҮЗ-ийн “Ердийн” гишүүдээр сонгон ажиллуулсугай.
Үүнд:

1.1.

2. Компанийн ТҮЗ-ийн гишүүдийг сонгох асуудалд хувьцаа эзэмшигчдийн олонхын санал авсан дараах нэр дэвшигчийг ТҮЗ-ийн “Хараат бус” гишүүдээр сонгон ажиллуулсугай.
Үүнд:

2.1.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан ТҮЗ-ийн ердийн гишүүн, хараат бус гишүүн нарыг өөрийн хүсэлтээр нь үүрэгт ажлаас нь чөлөөлж, ТҮЗ-ийн бүрэн эрхийг дуусгавар болгосугай.

4. Компанийн ТҮЗ-ийн гишүүдийг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газар болон бусад холбогдох эрх бүхий байгууллагад бүртгүүлэх, шаардлагатай бусад арга хэмжээг авч ажиллахыг Гүйцэтгэх захирал /С.Оргил/-д даалгасугай.

5. Энэхүү тогтоолын 4 дэх хэсэгт заасныг хэрэгжүүлэхэд шаардлагатай аливаа бүрэн эрхийг тус компанийн ТҮЗ-ийн Нарийн бичгийн дарга /Э.Цэлмэг/-д итгэмжилсүгэй.

ХУРЛЫН ДАРГА

А.СҮХДОРЖ


**Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулж,
дүрэм шинэчлэн батлах тухай**

Компанийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэг, 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, “МОСТ ФИНТЕК” ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.11.1 дэх заалт болон 2025 оны 04 сарын 25-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын ... дугаартай тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.39.1 дэх заалтад заасан “ХЭХ-аас эрх олгосны үндсэн дээр Компанийн охин, хараат компаниудын ХЭХ-ын бүрэн эрхийг хэрэгжүүлэх” гэсний “ХЭХ-аас эрх олгосны үндсэн дээр” гэснийг хасч “Компанийн охин, хараат компаниудын ХЭХ-ын бүрэн эрхийг хэрэгжүүлэх” хэмээн өөрчилсүгэй.
2. Энэхүү шийдвэрийн 1-т заасан өөрчлөлтийг оруулсан Компанийн дүрмийг энэхүү шийдвэрийн хавсралтаар баталсугай.
3. Энэхүү шийдвэрийн дагуу батлагдсан Компанийн дүрмийг Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу улсын бүртгэлд бүртгүүлэх, тийнхүү бүртгүүлэхтэй холбоотой аливаа арга хэмжээг авч хэрэгжүүлэх, дүрмийн хувийг Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлэхийг зэрэг ажлыг зохион байгуулж ажиллахыг компанийн Гүйцэтгэх захирал / С.Оргил/-д даалгасугай.
4. Энэхүү тогтоолыг хэрэгжүүлэхэд шаардлагатай аливаа бүрэн эрхийг тус компанийн ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга /Э.Цэлмэг/-д итгэмжилсүгэй.

ХУРЛЫН ДАРГА

А.СҮХДОРЖ



M·O·S·T
F I N T E C H